



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/661

Зуунмод

Өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигын эсрэг олон Улсын өдрийг тохиолдуулан залуу эрдэмтэн, судлаач, багш, оюутнууд, төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинэ технологи, шинэлэг санааг нэвтрүүлэх, авлигын эсрэг санаачилгыг өрнүүлэх зорилгоор зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Тус арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2,110,000 (хоёр сая нэг зуун арван мянга) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т зөвшөөрсүгэй.

3.Авлигын эсрэг олон Улсын өдрийг батлагдсан удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР

